**АЖИЛТНЫ НИЙГМИЙН**
**БАТАЛГААГ САЙЖРУУЛАХ ХӨТӨЛБӨР**

**(2018-2022)**

**УЛААНБААТАР ХОТ**
**2018 ОН**

## АГУУЛГА


| | |
|---|---|
| **Товчилсон үгийн тайлбар** | 3 |
| **Удиртгал** | 4 |
| **Нэг**. Нийтлэг үндэслэл | 4 |
| **Хоёр**. Зорилго, зорилт | 5 |
| **Гурав**. Хамрах хүрээ, хугацаа | 5 |
| **Дөрөв.** Хэрэгжүүлэх зарчим | 5 |
| **Тав**. Санхүүжилт | 5 |
| **Зургаа**. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирлага, зохион байгуулалт | 6 |
| **Долоо**. Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ үнэлгээ, шалгуур үзүүлэлт | 6 |
| **Найм**. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө | 6 |

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| ЦССҮТ | Цус сэлбэлт судлалын үндэсний төв |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| АХБ | Азийн хөгжлийн банк |
| ЦЦБ | Цус цусан бүтээгдэхүүн |
| СТСБА | Стратеги төлөвлөлт, санхүү, бүртгэлийн алба |
| ЧЦССА | Чанар, цусны сонор сэрэмжийн алба |
| ЭШХНХАА | Эрдэм шинжилгээ,хүний нөөц, хамтын ажиллагааны алба |
| ДЗБТ | Донор зохион байгуулалтын тасаг |
| НЛТ | Нэгдсэн лабораторийн тасаг |
| ТТ | Технологийн тасаг |
| ХЭМАБЗ | Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын зөвлөл |

**Удиртгал**

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйл, баримтлах зарчим

**Алсын хараа**

Цус сэлбэлт судлалын чиглэлээр Азидаа тэргүүлэгч орнуудын жишигт хүрнэ.

**Эрхэм зорилго**

Чадварлаг баг, дэвшилтэт технологи, инновацид тулгуурлан, үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд оршино.

**Үнэт зүйл**

- Мэргэшсэн, ёс зүйтэй, ур чадвартай хүний нөөц
- Тэгш хүртээмжтэй, чанартай, аюулгүй тусламж, үйлчилгээ
- Хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, техник, шинэ технологи, материаллаг нөөц
- Удирдлагын манлайлал, хариуцлага, ил тод байдал, эрхэм зорилго

**Баримтлах зарчим**

- Үйлчлүүлэгч төвтэй, хүнлэг энэрэнгүй, ил тод нээлттэй, тэгш хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх;
- Төрийн хуулийг чандлан сахиж, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдөх;
- Хувь хүний эрх ашиг, нэр төрийг хүндэтгэн нууцлалыг чандлах;
- Олон улсын нотолгоонд суурилсан дэвшилтэт технологид тулгуурлах;

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах хүрээнд Эрүүл мэндийн салбарт ажиллагсадын нийгмийн баталгаа, цалин хөлс, урамшууллыг нэмэгдүүлэх чиглэлээр сүүлийн жилүүдэд шат дараалсан арга хэмжээг бодлогын түвшинд авч хэрэгжүүлж тодорхой үр дүнд хүрч байгаа билээ. Тухайлбал эрүүл мэндийн салбарт ажиллагсадын мэргэжлийн онцлогийг тусгасан, бие даасан цалингийн ангилал, зэрэглэл бүхий дэд сүлжээг батлуулж, цалингийн доод жишгийг шинэчлэн тогтоосон, урамшууллын багцын олон хэлбэрт тогтолцоог нэвтрүүлэх, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтнийг урамшуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эмнэлгийн мэргэжилтэнд олгох тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлсэн зэрэг нааштай өөрчлөлтүүд гарч байна. Хэдий тийм боловч салбарын ажиллагсадын дунд халдварт өвчний эрсдэл, мэргэжлээс шалтгаалах өвчний тохиолдол өндөр,ажлын байрны аюулгүй байдлын баталгаа хангалтгүй байгаа, цалингийн худалдан авах чадвар сул, үнийн өсөлтийг гүйцэхгүй байгаа нь эрүүл мэндийн салбарын хүний нөөцөд тулгараад буй хямралыг улам гүнзгийрүүлэх эрсдэл дагуулж байна.

Ийнхүү ажиллагсадын цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох,

амьдрах болон ажиллах таатай, аюулгүй орчин бүрдүүлэх, хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах чиглэлээр санаачилгатай ажиллах шаардлага зүй ёсоор урган гарч байгаа тул ажиллагсадын нийгмийн асуудалд цогц байдлаар хандаж тэдний оролцоог хангах уялдаа холбоог сайжруулах зорилгоор энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

**Хоёр. Зорилго, зорилт**

2.1 **Зорилго**

Төвийн ажилтнуудын нийгмийн баталгааны түвшинг нэмэгдүүлэх, мэргэжлээс шалтгаалсан өвчин, өртөлт, ослын тохиолдлоос сэргийлэх, хөдөлмөрлөх үйл ажиллагааны явцад ажилтны эрүүл мэнд, амь насыг хамгаалах нөхцөлийг бүрдүүлэн мэргэжлийн эрсдлээс хамгаалахад оршино.

2.2 **Зорилт:**

- Ажилтнуудын нийгмийн баталгааг сайжруулах
- Ажлын байрны дэмжлэгт орчин бүрдүүлэх

**Гурав. Хамрах хүрээ, хугацаа**

3.1 ЦССҮТ-ийн нийт ажилтнууд хамрагдана. Төвийн нийт 73 ажилтны 17,(23,9%) эрэгтэй 54,(76.1%) эмэгтэй ба 33 (46.4%) нь залуу, 37 (52.1% ) нь дундаж, 1 (1.5%) нь ахмад насныхан байна.

3.2 Нийт ажилтнуудын албан тушаалын ангилалаар Удирдах албан хаагч 9,(12.6%), Мэргэжлийн албан хаагч 51 (71.8%), Техникийн гүйцэтгэх албан хаагч 11,(15.5%) байна. Мөн эмч, мэргэжилтнийг боловсролын болон мэргэжлийн зэрэг цолны байдлаар ангилвал: АУ-ны доктор, дэд профессор 1, Зөвлөх зэрэгтэй эмч 1, Клиникийн профессор 2, Тэргүүлэх зэрэгтэй эмч 4, Ахлах зэрэгтэй эмч 1, Тэргүүлэх зэрэгтэй сувилагч тусгай мэргэжилтэн 2, Ахлах зэрэгтэй сувилагч тусгай мэргэжилтэн 9, НЭММ 3, АУ-ны магистр 7
3.3 Хөтөлбөрийг 2018-2022 онд хэрэгжүүлнэ.

**Дөрөв. Хэрэгжүүлэх зарчим**

4.1 Энэхүү хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд гадаад болон дотоод орчны хүчин зүйлүүд шууд болон шууд бус нөлөөтэй бөгөөд тэдгээрийг нөлөөллөөр нь эрэмбэлэн тогтмол хянаж, давуу талаа ашиглан сул талаа багасгах, боломжийг ашиглан бэрхшээлийг багасгах зарчмийг баримтлана.
4.2 Монгол Улсын төрөөс ажиллах хүчний нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар баримтлах бодлого хууль тогтоомж, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенци, зөвлөмж, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, бодлоготой уялдуулан зохицуулах
4.3 Сонирхогч бүх талууд, төрийн, төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагуудын оролцоо, үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, түншлэлийг хөгжүүлэх
4.4 Үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, мэдээллийн урсгалыг бүрдүүлэх
4.5 Жендерийн мэдрэмжтэй байх

**Тав. Санхүүжилт**

5.1 Төвийн жил бүрийн төсөв
5.2 Олон улсын байгууллагуудын хөрөнгө оруулалт, хандивлагчдын туслалцаа
5.3 Бусад эх үүсвэр

**Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт**

6.1 ЭШХНХА-ны алба хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжлийн удирдлага, зохицуулалт мэдээллээр хангаж, хөтөлбөрийг төвийн хэмжээнд хэрэгжүүлэх, хэрэгжилтэд явцын хяналт тавих, дүгнэх ажлыг дотоод аудиторын оролцоотойгоор гүйцэтгэнэ.
6.2 Хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааны зарим хэсгийг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.

**Долоо. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ**

7.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг төвийн Дотоод аудитор, Үйлдвэрчний эвлэлийн хороо, ажилтнуудын төлөөллийн оролцоотойгоор хамтран хийж, УЗ-д тайлагнана.
7.2 Хөтөлбөрийг түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтийг баримтлан жил тутамд дүгнэж, харьцуулсан үнэлгээ өгнө.
7.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд шаардлагтай бол тухай бүрт нь шинэчлэл хийх

**Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө**

БАТЛАВ.
ЦССУТ-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Н.ЭРДЭНЭБАЯР

# АЖИЛТНЫ НИЙГМИЙН БАТАЛГААГ САЙЖРУУЛАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ /2018-2022/

| № | Үйл ажиллагаа | Хэрэгжих хугацаа | | | | | Шалгуур үзүүлэлт | Үр дүн | Хариуцах эзэн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | | | |
| **Зорилт 1. Ажилтнуудын нийгмийн хамгаалал** | | | | | | | | | |
| 1 | Ажилтнуудын цалин, хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог ажлын бүтээмжийг дээшлүүлэх хөшүүрэг болгох | + | + | + | + | + | Цалингийн өсөлтийн хувь, цалин нэмэгдлийн харьцаа Урамшууллын төрөл, тоо | Ажиллах урам зориг нэмэгдэж, ажлын бүтээмж сайжирна. | СТСБА, ЭШХНХАА, Үйлдвэрчний хороо |
| 2 | Нийгмийн хамгааллыг дэмжих сарын аяныг тогтмол зохион байгуулах | + | + | + | + | + | Жил бүрийн сарын аяны төлөвлөгөөний хэрэгжилт 100% хангагдсан байна. | Ажилтнуудын нийгмийн баталгаа сайжирна. | СТСБА, ЭШХНХАА, Үйлдвэрчний хороо |
| 3 | Ажилтнуудын эрүүл мэндийн судалгааг тогтмол хийж эрүүлжүүлэх арга хэмжээ авч ажиллах | + | + | + | + | + | Нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдсан ажилтны тоо, хувь, эрүүл болсон ажилтны тоо, хувь | Ажилтны сэтгэл ханамж сайжирна. | СТСБА, ЭШХНХАА, |
| 4 | Ажилтанд түлээ нүүрсний мөнгө болон нэг удаагийн тэтгэмж олгох | + | + | + | + | + | Жил бүр олгогдсон тоо, хувь, мөнгөн дүн | Ажилтан, ар гэрийн сэтгэл ханамж сайжирна. | СТСБА, ЭШХНХАА, Үйлдвэрчний хороо |
| 5 | Ажилтнуудыг хөнгөлттэй нөхцөлөөр рашаан сувилалд амрахад дэмжлэг үзүүлэх | + | + | + | + | + | Жил бүр дэмжлэг үзүүлсэн тоо, хувь, мөнгөн дүн | Ажилтны эрүүл мэндийн түвшин дээшилж хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэнэ. | СТСБА, Үйлдвэрчний хороо |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Онцгой ажлын байрыг ослын даатгалд хамруулах | | + | + | + | + | Ослын даатгалд хамрагдсан ажилтны тоо, эзлэх хувь | Ажилтны нийгмийн баталгаа хангагдана. | СТСБА, ЭШХНХАА |
| 7 | Ахмадын зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх | + | + | + | + | + | Хуулийн хүрээнд санхүүгийн болон арга зүйн дэмжлэг үзүүлсэн хэлбэр, давтамж | Ажилтны тогтвор суурьшилтай ажиллах урам зориг нэмэгдэнэ. | Төвийн ахмадын зөвлөл, СТСБА |
| **Зорилт 2. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайжруулах, Ажлын байрны дэмжлэгт орчин бүрдүүлэх** | | | | | | | | | |
| 8 | Эрүүл ажлын байрны шалгуур үзүүлэлтийг хангах | + | + | + | + | + | Шалгуур үзүүлэлт хангасан тухай баримтжуулалт | Ажлын байрны нөхцөл сайжирч, хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэнэ. | СТСБА, ЭШХНХАА |
| 9 | Ажлын байрны эрсдэлээс хамгаалах орчин бүрдүүлж, хөдөлмөр хамгааллыг сайжруулах | + | + | + | + | + | Мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн чадвар түр алдалтын тоо, эзлэх хувь, | Ажилтны сэтгэл ханамж сайжирна. | Бүх алба, тасаг ХЭМАБ-ын зөвлөл, Үйлдвэрчний хороо |
| 10 | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт ажилтнуудыг тогтмол хамруулах | + | + | + | + | + | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан ажилтны тоо, эзлэх хувь, давтамж | Ажилтнуудын эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэж, төлөвлөлт сайжирна. | СТСБА, ЭШХНХАА, Үйлдвэрчний хороо |
| 11 | Жил бүр ёс зүй, харилцаа хандлагаар тэргүүлэгч ажилтныг шалгаруулж урамшуулах | + | + | + | + | + | Жил бүр 1 ажилтны шалгаруулж, урамшуулсан байна. | Байгууллагын соёлд эерэгээр нөлөөлж, ажилтнуудын хандлага сайжирна. | СТСБА, Ёс зүйн хороо |
| 12 | Байгууллагын чийрэгжүүлэлтийн клубын үйл ажиллагааг сайжруулах | + | + | + | + | + | Жил бүр 1 тусгай зорилтын хөтөлбөрийг санаачилан хэрэгжүүлсэн байна. Уг хөтөлбөрт хамруулсан ажилтны тоо, хувь | Ажилтны эрүүл мэнд, бие бялдар, гоо зүйн төлөвшил сайжирч ажлын бүтээмж сайжирч, тогтмол орлоготой байна. | Сэтгэл нийцсэн үйлчилгээний баг, Үйлдвэрчний хороо |